

## Мянгад аялгууны “Эс үйл + жуу/жүү” бүтцийн хэл зүй, утга зүйн онцлог

## ТОЙМ ӨГҮҮЛЭЛ

Мягмарын САРУУЛ-ЭРДЭНЭ\*  
АНУ, Вашингтон, Конгрессын Номын Сан

**Хураангуй:** Орчин цагийн утга зохиолын монгол хэл буюу халх суурьтай баримжаа аялгууны цаг заах тогтолцоонд үйлийн зохистой ба зохисгүйг ялган заах хандлага төдий бус, тусгай ай нэгэнт үүсэн бий болжээ. Өнгөрсөн цагийн үгүйсгэх “-сангүй”, үргэлжилж буй одоо цагийн “-аад байна”, үргэлжилж буй одоо цагийн үгүйсгэх “-хгүй байна” хэлбэрүүд бүгд тухайн үйлийн зохисгүйг заах утгаараа нэгдмэл юм. Зохисгүй утга заах тусгай хэлбэр нь монгол хэлнээ цоо шинэ зүйл биш, Монголын нууц товчоон дахь үйлдэгдэх хэвийн хэрэглээ нь үйлийн эзнээс хамааралгүй болсон, хэцүү таагүй үйлд өртсөн утгыг илэрхийлдэг байв. Монгол бичгийн хэлний тэмдэг нэрээс үйл үг бүтээх -д болон -да/дэ дагаврын ялгаа ч мөн зохисгүй хэмээх утга мөн.

Энэхүү өгүүлэлд орчин цагийн мянгад аялгууны “Эс үйл үг + жуу” бүтцийг судалж, зохисгүй утга илтгэх тусгай хэлбэр болохыг нь батлах юм. Тэгэхлээр ерөөс үйлийн зохистой зохисгүйг ялган заах нь монгол хэлний төв аялгуу төдий бус нийт монгол хэл аялгуудын универсал шинжтэй үзэгдэл байж болох юм.

**Түлхүүр үг:** Мянгад аялгуу, хэл зүйн ай, зохистой зохисгүйн ай, зохисгүй утга

### Grammatical and Semantic Features of the “Эс verb + жуу/жүү” Structure in the Myangad dialect

SARUUL-ERDENE Myagmar  
Library of Congress, Washington D.C. USA

**Abstract:** In his previous research, the author concluded that the Modern Mongolian Standard Dialect, or Khalkha-based literary language, has already developed the category of “Unpleasantness.” The tendency to express unpleasant actions is not a new feature in the Mongolian language. Nicolas Poppe correctly noted that the passive

\* © М.Саруул-Эрдэнэ, 2024  
Email: msar@loc.gov

structure in the *Secret History of the Mongols* is used for actions that either indirectly affect the subject or are performed against the subject's will. In *Classical Mongolian Literary Language*, there are two different verb derivational suffixes: *-D* and *-Da/De*. Both suffixes derive verbs from adjectives, but with a key distinction: verbs formed with *-D* indicate regular actions, whereas verbs formed with *-Da/De* convey unpleasant actions. For example, *qolad-* means simply “to become or to get farther;” while *qolada-* means “to become too far” or “to become unpleasant due to excessive distance.” The Modern Mongolian Standard Dialect tense system clearly distinguishes between unpleasant actions. The past tense negative *-сангүй*, present continuous *-аад байна*, and present continuous negative *-хгүй байна* all indicate unpleasant actions.

In this paper, the author demonstrates that the Modern Mongolian Myangad dialect uses the verb structure “*Es Verb stem + juu*” to express unpleasant actions. This suggests that the category of “Unpleasantness” might be a universal feature across all Mongolian dialects.

**Keywords:** Myangad dialect, grammatical categories, category of unpleasantness

## 1. Удиртгал

Орчин цагийн монгол хэл гэсэн ерөнхий нэрийн доор зөвхөн Улаанбаатар төвтэй халхын аялгууны баримтыг авч үзсээр ирсэн нь учир дутагдалтай тул хэлний зүй тогтлын олон сонирхолтой асуудал, ялангуяа хэл зүйн тодорхой ай үнэхээр бүрэлдсэн эсэхийг нутгийн аялгууны баримтаар тодотгох нь чухал юм. Энэхүү өгүүлэлд Орчин цагийн монгол хэлний баримжаа аялгуунд зохистой ба зохисгүйг илтгэх хэл зүйн ай нэгэнт бүрэлдсэнийг мянгад аялгууны “Эс үйл + жуу/жүү” бүтцээр лавшруулан нотлох юм.

## 2. Мэдээлэгч, хэрэглээ

Мянгад аялгууг судлах эх үүсвэр буюу мэдээлэгч (informant) халхын Эрхэмбаяр, Ховд аймгийн Мянгад сумын уугуул, 61 настай (мэдээлэл авах үед), хөгжмийн зохиолч, тус сумын засаг даргаар ажиллаж байсан хүн. Мэдээлэгчтэй 2020 оны Нэгдүгээр сараас Тавдугаар сарыг хүртэлх хугацаанд нэг гэрт хамт суув.

Судалгааны объект болсон “Эс үйл + жуу/жүү” хэмээх хэлбэрийн хэрэглээний орчныг тодотгож өгвөл:

а. Нэг өдөр хөлдөөгчид бус, хөргөгчид махаа хийгээд мартсан байснаар өнөө мах муудсан байв. Мэдээлэгч үүнд өөрийгөө буруутган “Ээ, би эс харжуу” хэмээсэн юм. Яагаад ингэж хэлснийг нь асуухад “Би уг нь харах ёстой байсан юм, гэтэл харсангүй” хэмээн тайлбарлалаа.

б. Удалгүй энэ хэлбэрийг өөр үйл үгэн дээр, гэхдээ утга зүйн яг ижил орчинд ахин нэгэнтээ өгүүлэв. Мэдээлэгч бидэнд айраг бүлэх тухай зааж, гэртээ бүлсэн юм. Гэтэл нэг чухал зүйлийг хэлэхээ мартсан байжээ. Үүнээс болж айраг

ээдэв. Энэ тохиолдолд мэдээлэгч “Эс хэлжүү, би” хэмээн мөн өөрийгөө хэлэх ёстой байсан, хэлсэнгүйгээр ийм алдаа гарлаа гэсэн утгаар өгүүлэв.

с. Энэ хэлбэрийн тухай фейсбүүк дэх Ховд аймгийн Мянгад сумын хуудас дээр хэлэлцүүлэг өрнүүлэв. Үүнд нэгэн хэрэглэгч “Өө би энэ постыг эс анзаарч уу, харсан бол олон жишээ хэлж өгөх байж” хэмээсэн нь ижил утга мөн.

### 3. Бүтэц

“Эс үйл + жуу/жүү” хэмээх хэлбэр нь хэл зүйн ямар бүтцээс гаралтай болох нь сонирхолтой юм. Үүнд, баримжаа аялгууны “явж уу, ирж үү?” гэх мэт асуух хэлбэр болон монгол бичгийн хэлний “жухуй жүхүй” нөхцөлийн хоёр эгшгийн хоорондох Х гээгдэн урт эгшиг болсон байж болох, ийм хоёр таамаглалыг юуны түрүүнд авч үзсэн болно. Гэвч энэ хоёрын аль аль нь буруу болох нь хэлэн дэх хэрэглээгээр батлагдсан болно.

“Эс харж уу, эс хэлж үү, эс анзаарч уу” гэсэн энэхүү хэлбэр нь нэгд зөвхөн өнгөрсөн цаг, хоёрт, зөвхөн нэгдүгээр биеийн тухайд хэрэглэгдэж байна. Тийм учраас энэхүү хэлбэрийн бүтэц гарлыг мөшгөвөл:

Эс харжээ би > эс харж би > эс харжав > эс харжуу

гэсэн дарааллаар хувьссан бололтой. Угаас уруулын гийгүүлэгч сулрахдаа уруулын эгшиг болдог зүй тогтол монгол хэлэнд түгээмэл буйг жишээлбэл: “Яах вэ > яахав > яах вэ”, “Унаба жай > унав зай > унавзай > унуузай” гэх мэт.

### 4. Утга

Энэхүү хэлбэрийн илэрхийлж буй баймж утга маш сонирхолтой юм. Мянгад аялгуунаа өнгөрсөн цагийн үгүйсгэх хэлбэрийн -аагүй<sup>4</sup> нөхцөл идэвхтэй хэвээр буй. Гэтэл заавал “Эс үйл + ж-уу/ж-үү” гэсэн бүтцийг хэрэглэх орчин шаардлага, ялгаа нь юу байв?

Үүнд “хараагүй” гэвэл жирийн өнгөрсөн цаг, элдэв нэмэлт баймж утга үгүй бол “эс харжуу” нь “хараагүйн улмаас зохисгүй болсон, харах ёстой байгаад хараагүй” гэсэн харамсах утга илэрхийлж байна. Энэ нь орчин цагийн монгол хэлний баримжаа аялгууны цагийн айд нэгэнт бүрэлдсэн зохистой-зохисгүйг ялган заах хандлага чухам мөн.

Монгол хэлний хөгжлийн түүхийг авч үзвэл угаас монгол хэлэнд үйлийн зохистой зохисгүйг ялган заах хандлага нэлээд эртнээс бүрэлдсээр иржээ.

### 5. Монголын нууц товчоон дахь үйлдэгдэх хэв

Монголын нууц товчоон дахь үйлдэгдэх хэвийн утга хэрэглээний талаар Николас Поппе “Дуртгал”-даа ийн бичжээ:

“...Нууц товчоон дахь идэвхгүй буюу бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийн асуудал сонирхолтой. Үйлдэгдэх хэвд байгаа үйл үг шууд тусагдахууныг захирч

байгаа тийм бүтэц юм. Англи хэлэнд I was given a book – “Надад ном өгөгдсөн”, I was told a story – “Надад нэг түүх яригдсан” гэх мэт бүтэц цөөвтөр тохиолддог боловч арай ч тэр үеийн монгол хэлнийх шиг “бид малаа булаагдсан” (цаад утга нь бид малаа булаалгасан үйлийн хохирогч болсон) гэсэн бүтэц байдаггүй. Иймэрхүү бүтцийг зөвхөн хэл зүйн өгүүлэгдэхүүний өртсөн таагүй үйлд л хэрэглэдэг байсан бололтой. “Бид их сайхан бэлэг өгөгдсөн” гэх мэт өгүүлбэр огт тааралддаггүй...” (Поппе, орч:Саруул-Эрдэнэ, 2017: 265) Поппе энэ тухай бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэлдээ:

*“It denotes actions which directly affect the syntactic subject (he was caught), and actions which indirectly affect the subject or which are performed against the will of the subject, actions which do not depend on the syntactic subject (to be killed his brother)...”* (1964: 366-377) хэмээн зохистой зохисгүй, таатай таагүй үйлийг ялган зааж буйг ахин тодорхой батлаад, Монголын нууц товчооноос:

*Ekeyi kilinglagdaju ayun ba ayuba ... bi §244*

*Joci Darmala adu'uban de'ermetcü ottaju, nöködiyen jirüke yadagdaju §128* гэсэн жишээнүүдийг эш татсан юм.

## **6. Монгол бичгийн хэлний зохисгүй үйлийг илтгэх -да дагавар**

Дунд үеийн монгол хэлэнд ийнхүү үйлдэгдэх хэвийн бүтцээр зохисгүй үйлийг ялган илтгэх хандлага нэгэнт бий болсон байсан бол монгол бичгийн хэлэнд мөн таагүй, зохисгүй үйлийг ялгаж байжээ. Чой. Лувсанжав энэ тухай:

*“Нэр үгээс үйл үг бүтээх олон дагаврын дотроос онцын сонин хоёр дагавар бол -da -d хоёр юм... Тэмдэг нэр үндсэнд -d дагаврыг залгавал үйлдэхийн утгат үйл үндэс бүтээдэг. Жишээ нь: уртад- (урт бол), холад- (хол бол)... Тэмдэг нэрийн үндсэнд -da -de дагаврыг залгавал уг шинж чанар хэрээс хэтэрсэн, хүний сэтгэлд зохисгүй болохын утгат үйл үндэс бүтээдэг. Жишээ нь: уртада- (урт нь зохисгүй), холада- (хол нь зохисгүй)...”* (1986: 78-79) хэмээн бичжээ.

## **7. Орчин цагийн монгол хэлний баримжаа аялгууны цаг заах тогтолцоо дахь зохистой, зохисгүйн ай**

Энэ мэтээр үйлийн зохистой зохисгүйг ялган илэрхийлэх хандлага монгол хэлнээ бүрэлдсээр өнөөгийн халх аялгууны хувьд тусгай ай болон хөгжжээ. Монгол хэлний цаг заах тогтолцоонд зохисгүй үйлийг илэрхийлэх тусгай хэлбэр нэгэнт бий болсныг үзүүлбэл:

### **а. Энгийн өнгөрсөн цагийн үгүйсгэх хэлбэр**

Энгийн өнгөрсөн цаг нь орчин цагийн монгол хэлнээ -аагүй<sup>4</sup>, -сангүй<sup>4</sup> гэсэн хоёр өөр үгүйсгэх хэлбэртэй, үүнд -аагүй<sup>4</sup> энгийн өнгөрснийг заах бол -сангүй<sup>4</sup> нь зохисгүй утгыг илэрхийлж байна.

**Б.Булган, С.Оюун нар шүүх хуралд ирсэнгүй - Olloo.mn**

[olloo.mn/n/37068.html](http://olloo.mn/n/37068.html) ▼ [Translate this page](#)  
Dec 21, 2016 - Б.Булган, С.Оюун нар шүүх хуралд ирсэнгүй. С.Зоригийн амийг бүрэлгэсэн хэргийн шүүх хурал яг одоо ШШГЕГ-ын харьяа хорих 461-р ...

**ҮЗХ-ны хуралд лидерүүд нь ирсэнгүй - Chuhal.mn**

[chuhal.mn/r/14509](http://chuhal.mn/r/14509) ▼ [Translate this page](#)  
ТӨРИЙН ОРДНООС АН-ын ҮЗХ-ы хурлын ирц 60 хувьд хүрлээ. Дөнгөж сая ҮЗХ-ны хурал хаалтын горимд шилжлээ. Хуралд АН-ын лидерүүд болох ...

**Усан спорт сургалтын төвийг худалдан авах үнийн санал ирсэнгүй**

[eagle.mn/r/22576](http://eagle.mn/r/22576) ▼ [Translate this page](#)  
Jan 9, 2017 - Энэ онд нийслэлийн өмчит долоон газрыг худалдахаар төлөвлөөд байсан ба өнөөдөр Усан спорт сургалтын төв, Хан-уул дүүргийн ...

**Пак Гын Хэ шүүх хуралд хоёр дахь удаагаа ирсэнгүй - Mnb.mn**

[www.mnb.mn/i/105429](http://www.mnb.mn/i/105429) ▼ [Translate this page](#)  
Jan 5, 2017 - Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Пак Гын Хэ-тэй холбоотой хэргийг шүүх Үндсэн хуулийн шүүх хурлын хоёр дахь удаагийн сонгол ...

**Ээлжит бус чуулганы нээлтэд МАН-ын гишүүд ирсэнгүй - iKon.MN**

[www.ikon.mn/n/ivl](http://www.ikon.mn/n/ivl) ▼ [Translate this page](#)  
Эрх баригч АН 80 хувийн ирцтэй байсан бол МАН-ын гишүүдийн хэн нь ч чуулганд ирсэнгүй. Энэ талаар УИХ-ын дарга З.Энхболд "0 хувийн ирцтэй ...

**Зураг 1. “Ирсэнгүй” гэсэн үгээр хайхад Гүүглийн анхны илэрцүүд**

**Суудал тавьж өгсөнгүй хэмээн хутгалжээ - ZONE.mn**

[news.zone.mn/content/read/76393.htm](http://news.zone.mn/content/read/76393.htm) ▼ [Translate this page](#)  
Москвагийн метронд суудал тавьж өгсөнгүй хэмээн нэгэн зорчигчийг гэмт этгээд хутгалсан байна. Энэ хэрэг “Перово” өртөөн дээр гарсан бөгөөд тэд анх ...

**Тэд царайлаг болохыг хүссэн ч нэг л болж өгсөнгүй - ХороМ News**

[news.xorom.com](http://news.xorom.com) > Энтертаймент > Фото зураг ▼ [Translate this page](#)  
Feb 26, 2016 - Сайхан харагдахын тулд эмэгтэй хүн юуг ч хийж чадна. Харин зарим нэг эмэгтэйчүүдийн хувьд “сайхан” гэдэг ойлголт нь олонхийн санаа ...

**Тэд загварлаг харагдахыг хүссэн ч нэг л болж өгсөнгүй - ХороМ News**

[news.xorom.com](http://news.xorom.com) > Амьдрал > Загвар ▼ [Translate this page](#)  
Apr 28, 2016 - Баян хүн лаагаа иднэ үү, луувангаа иднэ үү, чамд хамаагүй гэж нэг үг байдаг. Түүнтэй адилаар бусдын юу өмсөж, яаж явах нь бидэнд ...

**“Баялгийг нь ашиглаж байгаа ч мэдээлэл өгсөнгүй” гэв**

[www.montsame.mn/oronnutag/41961](http://www.montsame.mn/oronnutag/41961) ▼ [Translate this page](#)  
“Баялгийг нь ашиглаж байгаа ч мэдээлэл өгсөнгүй” гэв. 2016 / 12 / 27 | 23:28 | Нийтэлсэн Д.Одонтунгааг. PDF version. “Нээлттэй Нийгэм форум”-ын ...

**МАН Лениний музейг өгсөнгүй - iKon.MN**

[www.ikon.mn/n/5cj](http://www.ikon.mn/n/5cj) - [Translate this page](#)  
В.И.Лениний музейг ССАЖЯ өөрийн мэдэлд авч, үлэг гүрвэлийн музей болгохоор ажиллаж байгаа. Харамсалтай нь энэ музейг МАН-ынхан өгөхгүй луу ...

**Ц.Мөнх-Оргил хангалттай тайлбар өгсөнгүй гэв - News.mn**

[www.news.mn/r/321304](http://www.news.mn/r/321304) ▼ [Translate this page](#)  
УИХ дахь Ардчилсан намын бүлгийн ээлжит хуралдаан өндөрлөж, хэлэлцсэн асуудлын талаар тус бүлгийн дарга С.Эрдэнэ сэтгүүлчдэд мэдээлэл ...

**Зураг 2. “Өгсөнгүй” хэмээх үгийн гүүгл хайлтын илэрц**

**в. Үргэлжилж буй одоо цаг**

Орчин цагийн монгол хэлний баримжаа аялгуунд үргэлжилж байгаа одоо цагийг илэрхийлэх “-ж байна”, “-аад<sup>4</sup> байна” хэмээх хоёр задлаг хэлбэр буй болжээ. Үүнд “-ж байна” нь энгийн үргэлжилж буй цагийг илэрхийлэх бол

“-аад<sup>4</sup> байна” нь хоёр өөр зүйлийн баймж утгыг зааж буй. Нэгдүгээрт, “одоогийн байдлаар, хараахан” гэсэн утгыг илтгэнэ. “Гурван гоол ороод байна. Арван хүн ирээд байна” гэх мэт өгүүлбэрийн утга нь “одоогийн байдлаар, өнөөхнийг хүртэл ийм байдалтай, цаашид ахиад гоол орно, хүн ирнэ” гэсэн санаа.

“-аад<sup>4</sup> байна” хэлбэрийн хоёр дахь утга бол үйл зохисгүй болж буйг илэрхийлэх санаа юм. Жишээг зургаар үзүүлбэл:

Л.Гантөмөр: НХХЯ-ыг халамжийн яам гэж бодоод байна - News.mn  
[www.news.mn/r/32594](http://www.news.mn/r/32594) ▼ [Translate this page](#)  
Хэлэлцүүлгийн төгсгөлд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг шинээр дахин боловсруулах нь зүйтэй гэж үзсэн байна. Учир нь хуулийн ...

Khos Bayar - Шуудангийн тооцоолуур чинь буруу бодоод байна ...  
<https://www.facebook.com/JT1CD/posts/10202689173445378.0> ▼ [Translate this page](#)  
Шуудангийн тооцоолуур чинь буруу бодоод байна.

Аархал - ЧИ ӨӨРИЙГӨӨ НЭЭХ ЗОВСОН АМЬТАН ГЭЖ БОДООД ...  
<https://www.facebook.com/Aarkhal/posts/551408981647706> ▼ [Translate this page](#)  
ЧИ ӨӨРИЙГӨӨ НЭЭХ ЗОВСОН АМЬТАН ГЭЖ БОДООД БАЙНА УУ ? ҮГҮЙ ЗА ГЭР ХОРООЛНЫ АЙЛУУД УС НЬ ДУУСХААР ЯАЖ УСАА АВДАГЫГ ЧИ ...

Банкууд зээлийн хүүгээ өөр өөр бодоод байна гэсэн эргэлзээ танд ...  
[sankhuuchbusgui.blogspot.com/2016/04/blog-post\\_17.html](http://sankhuuchbusgui.blogspot.com/2016/04/blog-post_17.html) ▼ [Translate this page](#)  
Арг 17, 2016 - Монголбанкнаас 2013 онд “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил, тод байдлын журам”-ыг баталсан ...

“ТЭД” буруу бодоод байна. Үгүй шүү дээ, огт үгүй - master1mgl  
<https://master1mgl.wordpress.com/.../аллага-хүчирхийллээр-зорь...> ▼ [Translate this page](#)  
Jan 2, 2015 - Аллага хүчирхийллээр зорьсондоо хүрч болно гэж “ТЭД” буруу бодоод байна. Үгүй шүү дээ, огт үгүй: Цагаан, Улаан аль нь ч тэр, ...

### Зураг 3. “Бодоод байна” гэсэн үгээр хайхад илрэх эхний тохиолдлууд

Чоно харайх голын гүүр нурах аюулд ороод байна  
[inspection.gov.mn/info/index.php?option=com...](http://inspection.gov.mn/info/index.php?option=com...) ▼ [Translate this page](#)  
Чоно харайх голын гүүр нурах аюулд ороод байна ... илүү даацтай том тээврийн хэрэгсэл дамжин өнгөрдөгөөс гүүр нурах шахах аюулд ороод байна.

Германд 1450 нислэг өөрчлөхөд хүрч 200 орчим зорчигч хүнд ...  
[mongolnews.mn/1c4n](http://mongolnews.mn/1c4n) - [Translate this page](#)  
... 1450 нислэг өөрчлөхөд хүрч 200 орчим зорчигч хүнд байдалд ороод байна ... эхэлж мягмар гарагийн 21,59 цаг хүртэл үргэлжлэх юм байна Нисгэгчдийн ...

“Бид лидерийн хомсдолд ороогүй ээ, харин шийдвэр гаргалтын ...  
[www.ikon.mn/n/cbp](http://www.ikon.mn/n/cbp) ▼ [Translate this page](#)  
Зарим хүний ярьдагчлан бид лидерийн хомсдолд ороогүй ээ, харин шийдвэр гаргалтын хомсдолд л ороод байна. Засаг солигдох саяны хоёр долоо ...

Уран бичлэг, хөөмий, биелгээ устах аюулд ороод байна - News.mn  
[www.news.mn/r/264442](http://www.news.mn/r/264442) ▼ [Translate this page](#)  
Хамгийн сүүлд л гэхэд манай улсаас уран бичлэгийг соёлын өвд бүртгүүлсэн байна. Мөн өнгөрсөн онд шагайн харвааны наадгайг Юнеско-д бүртгүүлжээ ...

Kendra Wilkinson хүнд байдалд ороод байна - News.mn  
[www.news.mn/r/13771](http://www.news.mn/r/13771) ▼ [Translate this page](#)  
Миний нөхөр ийм хэцүү үед намайг ойлгож байгаад би их баяртай байна. Зургаан жилийн өмнөх бичлэгээр одооны амьдралыг минь битгий дүгнээсэй ...

Японы хэвлэлийн эрх чөлөө аюулд ороод байна - 24Tsag.mn  
[www.24tsag.mn/content/133463.shtml](http://www.24tsag.mn/content/133463.shtml) ▼ [Translate this page](#)  
НҮБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөө болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх асуудлын тусгай тайлагнагч, АНУ-ын Калифорнийн Их Сургуулийн ...

### Зураг 4. “Ороод байна” гэсэн үгийн Гүүглийн анхны илэрцүүд

“-аад<sup>4</sup> байна” хэлбэр нь ийнхүү зохисгүй болж буй утгыг илэрхийлдэг учраас эмнэлгийн газарт, өвчтөний шинж тэмдгээ илтгэх өгүүлэмжид байнга энэ хэлбэр тохионо. Жишээлбэл, “Толгой өвдөөд байна. Жихүүдэс хүрээд байна. Бөөлжис цутгаад байна. Толгой эргээд байна. Тархи хатгаад байна...” гэх мэт.

### с. Үргэлжилж буй одоо цагийн үгүйсгэх хэлбэр

Үргэлжилж буй одоо цаг нь “-аагүй<sup>4</sup> байна”, “-хгүй байна” гэсэн хоёр хэлбэртэй. Үүнд “-аагүй<sup>4</sup> байна” хэлбэр нь энгийн утга илэрхийлэх бол “-хгүй байна” хэлбэрээр ямагт зохисгүй үйлийн утга илэрнэ. Жишээг Гүүглийн илэрцээр үзүүлбэл:

[Төрийн ордонд ажил явахгүй байна - Mongolnews.mn](#)

[mongolnews.mn/1s3w](http://mongolnews.mn/1s3w) ▼ [Translate this page](#)

Чуулганы танхим гишүүдээ хүлээсээр. Өглөө 08.30 цагт хуралдах ёстой Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан ирц бүрдээгүйгээс 13.30 цаг ...

[Outlook-с болон webmail-с явахгүй байна? - Мэдлэгийн сан - iTools ...](#)

<https://secure.itools.mn/knowledgebase.php?action=displayarticle...> ▼ [Translate this page](#)

Хэрвээ таны имэйл outlook-с болон webmail-с явахгүй байгаа бол доорхи шалтгаануудын улмаас явахгүй байх боломжтой. 1. Аль нэг имэйл хэрэглэгч нэг ...

[Имэйл илгээхээр SPAM гээд явахгүй байна - Мэдлэгийн сан - iTools ...](#)

<https://secure.itools.mn/knowledgebase.php?action=displayarticle...> ▼ [Translate this page](#)

Имэйл илгээхээр SPAM гээд явахгүй байна. Хэрвээ таны бизнес имэйлийн үйлчилгээнээс имэйл илгээхээр SPAM гээд явахгүй байгаа бол шалтгаанууд нь ...

[Тэр хүүхэн одоо болтол гэрээс маань явахгүй байна - Секс.мн](#)

[www.cekc.mn](http://www.cekc.mn) › Гэр бүл ▼ [Translate this page](#)

Jan 17, 2017 - Би яах учраа олохгүй байна. Би хэнд хандахаа ч мэдэхгүй байна. Хамгийн гол нь тэр хүүхэн одоо болтол гэрээс маань явахгүй байна.

[Хорооллоос-Улиастайн чиглэлд унаа явахгүй байна - News.mn](#)

[www.news.mn/r/19049](http://www.news.mn/r/19049) ▼ [Translate this page](#)

Дээрх чиглэлийн унааг хүлээж, зорчигчид нэг цаг шахам 100 айлын автобусны буудал дээр халуун наранд шарагдан зогсож байна. Гэтэл Хороолол III ...

**Зураг 5. “Явахгүй байна” хэмээх үгийн анхны илэрцүүд**

**МАН-ын бүлгийнхэн байнгын хороодын хуралдаанд суухгүй байна**  
[mongolnews.mn/Сонин-хачин/1г7е](http://mongolnews.mn/Сонин-хачин/1г7е) - Translate this page

МАН-ын бүлгийнхэн байнгын хороодын хуралдаанд **суухгүй байна**. 2015 оны 12 сарын 09. УИХ-ын Төсөв болон Эдийн засгийн байнгын хороо өнөөдөр ...

**“БУУХИА АВТОБУС”-нд ХҮН СУУХГҮЙ БАЙНА - Эхлэл**

[entertainment.mongolnews.mn/Архив/ud4](http://entertainment.mongolnews.mn/Архив/ud4) - Translate this page

Хяналтын байцаагчид “Ингэж хянахгүй бол иргэдэд үйлчилж байна гэж ... Гэтэл буухиа автобусанд хүн бараг **суухгүй** байгааг өмнөх гурван өдрийн турш ...

**“Буухиа автобус”-нд хүн суухгүй байна - GoGo News**

[news.gogo.mn/r/118129](http://news.gogo.mn/r/118129) - Translate this page

“Буухиа автобус”-нд хүн **суухгүй** байна. Цагаан сар дөхөхөөр худалдааны төвүүдийн ачаалал ихэсч, үүнийг дагаад замын хөдөлгөөн түгжирдэг.

**Материал хангалтгүй учир гишүүд хуралд суухгүй байна гэв | Sonin ...**

[www.sonin.mn/news/politics-economy/52579](http://www.sonin.mn/news/politics-economy/52579) - Translate this page

Материал хангалтгүй учир гишүүд хуралд **суухгүй** байна гэв. Нийтэлсэн: 2015-11-25 14:41:00. УИХ-ын Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороо ...

**МАН-ынхан хуралдаа суухгүй байна - EAGLE.mn**

[eagle.mn/r/2605](http://eagle.mn/r/2605) - Translate this page

Jan 21, 2016 - Засгийн тэргүүнийг огцруулах бичигт гарын үсэг зурсан нөхөд хэлсэн үг, хийсэн үйлдэлдээ эзэн болсонгүй гэх шүүмжлэл ч гараад байна.

**МАН-ынхнаар далимдуулж АН-ынхан хуралдаа суухгүй байна**

[vip76.mn/content/37303](http://vip76.mn/content/37303) - Translate this page

Dec 16, 2015 - МАН-ынхан байнгын хороо, чуулганы хуралдаанд **суухгүй** гэдгээ илэрхийлснээр төрийн ажил гацаанд ороод байна. Тэгвэл МАН-ыхнаар ...

### **Зураг 6. “Суухгүй байна” хэлбэрийн анхны илэрцүүд**

Энэ бүх жишээнээс үзэхэд өнгөрсөн цагийн үгүйсгэх “-сангүй<sup>4</sup>”, үргэлжилж буй одоо цагийн “-аад<sup>4</sup> байна”, үргэлжилж буй одоо цагийн үгүйсгэх “-хгүй байна” хэлбэрүүд нь энгийн цагтайгаа эсрэгцэж, зохисгүй үйлийг илтгэх утга нь тогтмол, зүй тогтлын шинжтэй ажээ.

Судлаач Ц.Өнөрбаяны “Нэг төрлийн ерөнхий хийсвэр харьцаа зааж байгаа хоёр ба түүнээс дээш харилцан эсрэгцсэн хэл зүйн утгуудын нэгдэл (цогцос)-ыг хэл зүйн ай гэнэ” (2004: 14) хэмээх тодорхойлолт, А. И. Исхаков, Б. Н. Головин нарын хэл зүйн утга, хэл зүйн хэлбэр хоёрын нийлцийг хэл зүйн ай гэнэ гэх санааг бодолцон үзэхэд орчин цагийн монгол хэлнээ үйлийн зохистой зохисгүйг ялган заах утга нь ч буй, түүнийг илэрхийлэх хэл зүйн хэлбэрүүд нь ч бий болсон учраас бид энд орчин цагийн монгол хэлний үйл үгийн цагийн ай дотор зохистой зохисгүйг илтгэн заах дэд ай мөн буй хэмээн зоригтой дүгнэж байгаа юм.

## **8. Дүгнэлт**

1. Орчин цагийн монгол хэлний баримжаа аялгуунд үйлийн зохистой зохисгүйг ялган заах хэл зүйн ай нэгэнт буй болжээ.
2. Мянгад аялгууны нэгдүгээр биеийн “эс үйл + жуу/жүү” хэлбэр нь мөн зохисгүй утгыг ялган заадаг өвөрмөц хэлбэр мөн байна.



3. Утга зохиолын хэлнээ нэгэнт бүрдсэн энэхүү айд хамаарах тусгай хэлбэр мянгад аялгуунд мөн үүссэн байгаа нь зохистой зохисгүйг ялган заах хандлага нь зөвхөн баримжаа аялгууны үзэгдэл биш, ерөөс нийт монгол хэл аялгуудын универсал шинжтэй явц болохыг үзүүлж байна. Бусад аялгууны баримтыг, ялангуяа баяд, дөрвөдийн аялгуу дахь “явжгүй, иржгүй” гэх мэт үгэнд тохиож буй “-жгүй” гэсэн өнгөрсөн цагийн үггүйсгэх хэлбэр нь чухам ийм утга илтгэж буй эсэх талаар судлах шаардлагатай юм.

### Ном зүй

- Лувсанжав, Чой.** (1986). *Монгол бичиг* - 8, Улаанбаатар. [Luvsanjav, Choi. *Mongol bichig* - 8 [Mongolian Script - 8] Ulaanbaatar, 1986]
- Өнөрбаян, Ц.** (2004). *Орчин цагийн монгол хэлний үг зүй*, Улаанбаатар. [Önörbayan, Ts. *Orchin tsagyn mongol helnii üg züi* [Modern Mongolian Morphology] Ulaanbaatar, 2004]
- Поппе, Н.Н.** (2017). *Дуртгал*. Орч. М. Саруул-Эрдэнэ, Улаанбаатар: Сэлэнгэ пресс. [Nicolas Poppe, *Reminiscences*, translated by M.Saruul-Erdene, Ulaanbaatar: Selenge Press]
- Nicolas Poppe.** (1964). The Passive Constructions in the Language of Secret History of the Mongols, *Ural-Altische Jahrbücker* 36 (1964), pp.366-37



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.